

## **Заг хүйтэн, өвчтөнд өгөх мэдээлэл (2016-10-21)**

*Халдвар хамгааллын эмч нарын халдвар хамгааллын хуудас.*

### **Танд яагаад энэ мэдээллийг өгсөн бэ?**

Та заг хүйтний халдвар авсан эсвэл авсан байх магадлалтай. Энэ хуудсанд заг хүйтэн, үүнийг хэрхэн эмчлэх ба та яах ёстой талаар мэдээлэл бий.

### **Заг хүйтэн гэж юу вэ?**

Заг хүйтэн нь ихэнхдээ шээсний сув, үтрээ, шулуун гэдэс ба хоолойн салст бүрхэвчид суудаг бактери юм.

### **Яаж заг хүйтэнтэй болдог вэ?**

Заг хүйтэн голдуу үтрээний эсвэл шулуун гэдэсний хавытал, мөн заримдаа амаар бэлгийн харьцаанд ороход тархдаг. Заг хүйтэн мөн петтинг\* ба секс тоглоомоор тархана.

Заг хүйтэн хувцас, алчуур эсвэл жорлонгоор дамжихгүй, учир нь энэ бактери биеэс гадуур амьдрах чадваргүй. Заг хүйтний халдвартыг хэд хэдэн удаа авч болно.

\*Петтинг = “таалах”, хавьтахгүйгээр бие бие таалах, харилцан гар хангалаа хийх.

### **Заг хүйтэнтэй болсноо хүн мэдэх үү?**

**Халдвар авсан зарим хүмүүст шинж тэмдэг байдаггүй, өөрөөр хэлбэл хүн халдвартай гэдгээ мэддэггүй.**

**Зарим хүмүүс шээхэд хорсож байгааг мэдэрнэ. Зарим хүмүүсийн хоолойд бактери суусан бол хоолой өвдөнө.**

**Эмэгтэйчүүдийн үтрээнээс шар өнгийн шингэн гарах мөн / эсвэл хэвлийн доогуур хэсгээр өвдөж болно. Эрчүүдийн шээсний сувнаас шингэн ялгарах ба төмсөг өвдөж болно. Шулуун гэдсээр хавьтсан бол тэндээс шингэн гарч болно. Ямар ч шинж тэмдэггүй ч байсан заг хүйтэн маш өндөр халдах чадвартай.**

### **Заг хүйтэн аюултай юу?**

Эмчлүүлэхгүй бол эмэгтэйчүүд өндгөвчний сувагтаа гэмтэл авч, тэр нь тэднийг жирэмслэхэд хэцүү болгох эсвэл үр хөврөл умайн гадна тогтоход хүргэж болно (савны гадуурх жирэмслэлт). Эрчүүдийн төмсөгний дайвар эрхтэн үрэвсэж болно. Заг хүйтэн мөн нүдний халдвар ба томоохон үе мөчид үрэвсэл үүсгэж болно.

### **Заг хүйтэнг яаж эмчлэх вэ?**

Заг хүйтэнг антибиотикоор (тариа эсвэл эм) эмчилнэ. Та эмийг зааврын дагуу хэрэглэж, өөрт өгсөн бусад зөвлөгөөг дагавал, халдвар арилна. Эмчилгээ үнэгүй.

Таныг давтан ирэхээр дуудсан бол та заавал очих ёстой. Халдвар арилсан эсэхийг шалгах зорилгоор шинэ шинжилгээ авах шаардлагатай байж болно.

Та заг хүйтэнтэй болбол өөр хүнд халдаах эрсдэл авч болохгүй. Эмч таныг бүрэн эмчлэгдсэн гэж хэлтэл та бусадтай хавьтах эсвэл өөр төрлийн бэлгийн харьцаанд орохгүй байх нь баталгаатай. Та бэлгийн харьцаанд орвол нөгөө хүндээ өөрийгөө заг хүйтэнтэйг хэлж хамгаалалт (бэлгэвч) хэрэглэх ёстой.

### **Халдварын мөрдөлт - энэ юу вэ?**

Заг хүйтэнтэй хүмүүсийг олж тэднийг эмчлэх нь маш чухал, энэ нь нэгд, гэмтэл (дээр дурдсан) үүсэх эрсдэлийг багасгах, хоёрт, халдвартыг олон хүмүүст тараахгүй байхад чухал.

Та заг хүйтэнтэй бол халдвар мөрдөгчид өөрийнхөө хавьтсан / бэлгийн харьцаанд орсон (заримдаа сүүлийн сүүлийн нэг жилийн хугацаанд) хүн, хүмүүсийг хэн болохыг хэлэх

ёстай.

Таны халдвар мөрдөгчид хэлсэн зүйл нууц (нууцлал). Таны мэдээлсэн хүмүүс таныг хэн гэдгийг мэдэхгүй. Тэд өөрсдийгөө шинжлүүлэх ёстой гэдгийг л сонсоно.

## Заг хүйтэн Халдвараас хамгаалах хуульд тусгагдсан - энэ юу гэсэн үг вэ?

Халдвараас хамгаалах хуульд заг хүйтэн мэт өвчинг зогсоож бусдад тараахгүй байлгахын тулд баримтлах дүрэм журам бий. Заг хүйтэнтэй эсвэл тийм байх магадлалтай та, өөрийн эмчийн өгөх дараах дүрэм журмыг мөрдөх ёстай.

- Эмч танд эргэж ирэх цаг өгвөл ирэх ёстай.
- Та бэлгийн харьцаанд орохдоо өөрийгөө заг хүйтэнтэй эсвэл тийм байх магадлалтай гэдгийг хэлэх ёстай.
- Та өөрийн эмчилгээ/шинжилгээг хийлгэж дуусаагүй нөхцөлд бэлгийн харьцаанд орохдоо хамгаалалт хэрэглэх ёстай.

Та өөрт мөрдүүлэхээр өгсөн дүрэм журмыг буруу гэж үзэж байвал өөрийн харьяаллын эмнэлгийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно.

## Та нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?

Заг хүйтний талаар нэмэлт мэдээллийг дараах цахим хуудсаас уншиж болно.  
[www.1177.se](http://www.1177.se)

[www.folkhalsomyndigheten.se](http://www.folkhalsomyndigheten.se)

[www.umo.se](http://www.umo.se) (интернет дэх өсвөр үеийнхэн залуучуудын эмнэлэг)

## Сайн дурын мэдээллийн цонх (*frivillig informationsruta*)

Та дараах хүмүүстэй уулзсан (*Du har träffat*)

.....

Халдвар мөрдөлтийн захиалсан цаг (*Smittspärning bokad datum*)

.....

Дараагийн давтан цаг (*Nästa återbesök*)

.....

Хүлээн авах эмнэлгийн утас / утасны цаг (*Telefonnummer/telefontid till mottagningen*)

.....